



**НИЙСЛЭЛИЙН НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ТУСГАЙ ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 12 сарын 15 өдөр

Дугаар А/30

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэлд авах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 3.2.4 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2020 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн А/1231 дүгээр захирамж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн А/126 дугаартай тушаал, төвийн даргын 2019 оны А/10 тоот тушаалаар баталсан "Нийгмийн хамгааллын тусгай төвийн хөдөлмөрийн дотроод журам"-ын 2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2020 онд нийслэлийн төсвийн хөрөнгөөр худалдан авсан 32 000 000 /гучин хоёр сая/ төгрөгийн иж бүрэн 10 /арав/ гэр , 4 750 000 /дөрвөн сая долоон зуун тавин мянган/ төгрөгийн 25/хорин тав/ ширхэг модон ор, нийт 36 750 000 /гучин зургаан сая долоон зуун тавин мянга/ төгрөгийн эд хогшлыг үндсэн хөрөнгийг данс бүртгэлд авахыг нягтлан бодогч /Б.Энхдэлгор/-д үүрэг болгосугай.
2. Худалдан авсан хөрөнгийн ашиглалт хамгаалалтад хяналт тавин ажиллахыг нярав /Б.Отгонсайхан/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Г.ЦЭРЭНДУЛАМ

318060392

Нийгмийн хамгааллын тусгай төвийн даргын
2020 оны 02 сарын 04 ны өдрийн
дугаартай тушаалын хавсралт



Худалдан авсан эд хогшлын жагсаалт

№	Нэр төрөл	Тоо, Хэмжээ /ширхэг/	Нэгж үнэ /Төгрөг/	Бүгд үнэ /Төгрөг/
1	Иж бүрэн гэр	10	3 200 000	32 000 000
2	Модон ор	25	190 000	4 750 000
Нийт		35		36 750 000